

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/24/-НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Ундраа: Утас: 7036-2442 Цахим хаяг: undraats@audit.gov.mn |
|---|---|

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|-------|
| 1. Аудитын дүгнэлт | 3-4 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5-10 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга | 11 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 11 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 12 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт | 12 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 13-14 |
| 4. Аудитын тайлан | 15 |
| 4.1 Ерөнхий зүйл | 15 |
| 4.2 Материаллаг байдал | 15 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 15 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 16 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 16 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 16 |
| 5. Аудитын илрүүлэлт | 17 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл | 18 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| ХЗДХ | Хууль зүй, дотоод хэрэг |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Б.САРАНЧИМЭГ ТАНАА

2024. 1. 23 № САА-2024/24-НД-САА-1113
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 59.0 хувиар нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд УБЕГ-ын хөрөнгө оруулалтаар 69,160.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж нийлүүлснийг байгууллагын байранд суурилуулснаар лавлагаа, хил нэвтрэх үнэмлэх олгох зэрэг үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант оны Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г 9 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 91.5 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 103,703,136.90 | 100,899,708.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 185,999.70 | 00.00 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 185,999.70 | 00.00 |
| 3121 | Төгрөг | 185,999.70 | 00.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 185,999.70 | 00.00 |
| 33 | АВЛАГА | 19,800,000.00 | 00.00 |
| 335 | Бусад авлага | 19,800,000.00 | 00.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 19,800,000.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 83,717,137.20 | 100,899,708.00 |
| 351 | Түүхий эд материал | 38,924,607.20 | 48,641,598.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 38,924,607.20 | 48,641,598.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 6,163,385.00 | 10,552,870.00 |
| 354 | Хангамжийн материал | 38,629,145.00 | 41,705,240.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,926,020.00 | 3,249,165.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,911,725.00 | 24,956,725.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 294,000.00 | 2,924,950.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 42,000.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,455,400.00 | 10,574,400.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 219,520,246.61 | 215,915,313.42 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 219,520,246.61 | 215,915,313.42 |
| 392 | Биет хөрөнгө | 215,200,246.61 | 211,595,313.42 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 29,400,000.00 | 29,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -10,208,333.25 | -15,108,333.21 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 368,500,879.61 | 437,660,979.61 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -172,990,401.66 | -244,807,332.99 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 21,174,411.50 | 34,774,411.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -20,676,309.59 | -30,324,411.49 |
| 393 | Биет бус хөрөнгө | 4,320,000.00 | 4,320,000.00 |
| 39301 | Программ хангамж | 7,043,200.00 | 7,043,200.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -7,043,200.00 | -7,043,200.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 4,320,000.00 | 4,320,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 323,223,383.51 | 316,815,021.42 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 185,999.70 | 00.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 185,999.70 | 00.00 |
| 414 | Урьдчилж орсон орлого | 185,999.70 | 00.00 |
| 41410 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 185,999.70 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 323,037,383.81 | 316,815,021.42 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 323,037,383.81 | 316,815,021.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 4,320,000.00 | 4,320,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 4,320,000.00 | 4,320,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 318,717,383.81 | 312,495,021.42 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 318,717,383.81 | 318,717,383.81 |

| | | | |
|-------------|--|-----------------------------|-----------------------------|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 82,750.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 4,410,900.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 4,046,804.20 | 34,614,034.20 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 66,508,253.20 | 79,549,903.23 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,514,410.00 | 6,914,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 871,600.00 | 1,300,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 55,122,243.20 | 71,335,903.23 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,540,182.37 | 39,691,898.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,315,000.00 | 36,747,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,315,000.00 | 2,800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 6,225,182.37 | 2,944,198.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>1,788,092.60</u> | <u>12,587,637.61</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 6,500,000.00 | 18,810,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 6,500,000.00 | 18,810,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -6,500,000.00 | -18,810,000.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>-4,711,907.40</u> | <u>-6,222,362.39</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|------------------------------|--------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>992,235,373.23</u> | <u>1,488,222,062.10</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 290,997,473.23 | 339,949,262.10 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 290,997,473.23 | 339,949,262.10 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 290,997,473.23 | 339,949,262.10 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 290,997,473.23 | 339,949,262.10 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 701,237,900.00 | 1,148,272,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 688,976,400.00 | 1,139,248,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 688,976,400.00 | 1,139,248,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,261,500.00 | 9,024,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны | 12,261,500.00 | 6,714,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>992,049,373.53</u> | <u>1,488,408,061.80</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 992,049,373.53 | 1,488,408,061.80 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 693,697,717.63 | 1,108,380,902.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 553,473,958.63 | 937,658,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 449,950,895.29 | 649,843,582.26 |
| 210102 | Нэмэгдэл | 91,380,523.25 | 203,844,754.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,142,540.09 | 57,970,163.72 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 74,205,500.00 | 129,357,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,459,700.00 | 93,051,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,936,400.00 | 11,476,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,749,200.00 | 6,621,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,187,300.00 | 1,655,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,872,900.00 | 16,553,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,054,900.00 | 6,723,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,273,300.00 | 1,363,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,092,000.00 | 3,829,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,510,800.00 | 1,418,000.00 |

| | | | |
|-------------|--|--------------------------|---------------------------|
| 210304 | Байрны түрээс | 178,800.00 | 112,300.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,959,199.00 | 17,730,802.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,886,591.00 | 11,586,605.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,660,000.00 | 2,695,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,273,739.00 | 1,581,540.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,138,869.00 | 1,867,657.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 24,130,300.00 | 3,397,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,061,100.00 | 1,144,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 887,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,182,200.00 | 2,253,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,839,850.00 | 5,500,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,168,000.00 | 1,089,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 89,100.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 82,750.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 4,410,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,034,010.00 | 8,014,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,162,410.00 | 6,714,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 871,600.00 | 1,300,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 298,351,655.90 | 380,027,159.80 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,315,000.00 | 36,947,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,315,000.00 | 3,000,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 297,036,655.90 | 343,079,459.80 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 295,937,565.90 | 331,825,009.10 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>185,999.70</u> | <u>-185,999.70</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 185,999.70 | -185,999.70 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 185,999.70 | 00.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| / төгрөгөөр / | | | | | | |
|---------------|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|--|
| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| C01 | 2013 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 4,320,000.00 | 00.00 | 67,044,607.10 | 00.00 | 71,364,607.10 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 8,130,875.81 | 00.00 | 8,130,875.81 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,320,000.00 | 00.00 | 75,175,482.91 | 00.00 | 79,495,482.91 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 50,380,570.02 | 00.00 | 50,380,570.02 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 4,320,000.00 | 00.00 | 318,717,383.81 | 00.00 | 323,037,383.81 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 4,320,000.00 | 00.00 | 318,717,383.81 | 00.00 | 323,037,383.81 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,320,000.00 | 00.00 | 318,717,383.81 | 00.00 | 323,037,383.81 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -6,222,362.39 | 00.00 | -6,222,362.39 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 4,320,000.00 | 00.00 | 312,495,021.42 | 00.00 | 316,815,021.42 |

| | | | |
|---|--|-----------------------|-----------------------|
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>323,223,383.51</u> | <u>316,815,021.42</u> |
|---|--|-----------------------|-----------------------|

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 751,992,640.00 | 1,266,628,290.04 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 50,754,740.00 | 118,355,490.04 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 50,754,740.00 | 118,355,490.04 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 50,754,740.00 | 118,355,490.04 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 701,237,900.00 | 1,148,272,800.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 688,976,400.00 | 1,139,248,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 688,976,400.00 | 1,139,248,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,261,500.00 | 9,024,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,261,500.00 | 6,714,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 750,204,547.40 | 1,254,040,652.43 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 750,204,547.40 | 1,254,040,652.43 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 742,664,365.03 | 1,214,348,754.43 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 553,473,958.63 | 937,658,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 449,950,895.29 | 649,843,582.26 |
| 210102 | Нэмэгдэл | 91,380,523.25 | 203,844,754.02 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,142,540.09 | 57,970,163.72 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 74,205,500.00 | 129,357,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,459,700.00 | 93,051,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,936,400.00 | 11,476,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,749,200.00 | 6,621,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,187,300.00 | 1,655,300.00 |
| 210205 | Эрүүл-мэндийн даатгал | 11,872,900.00 | 16,553,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 11,054,900.00 | 6,723,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,273,300.00 | 1,363,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,092,000.00 | 3,829,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,510,800.00 | 1,418,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 178,800.00 | 112,300.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,219,299.00 | 17,250,717.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,213,091.00 | 11,726,520.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,308,000.00 | 2,695,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,273,739.00 | 1,497,540.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,424,469.00 | 1,331,657.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,315,800.00 | 3,695,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 284,400.00 | 950,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,475,200.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,556,200.00 | 2,745,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,886,654.20 | 40,114,034.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний | 2,168,000.00 | 1,089,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 89,100.00 | 00.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|-----------------------|--|-----------------------|------------------|----------------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,139,248,800.00 | 1,136,304,602.00 | 2,944,198.00 | 99.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,139,248,800.00 | 1,136,304,602.00 | 2,944,198.00 | 99.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,103,801,100.00 | 1,101,356,902.00 | 2,444,198.00 | 99.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 937,658,500.00 | 937,658,500.00 | 0.00 | 100 |
| 210101 | Үндсэн цалин | 699,683,700.00 | 649,843,582.26 | 49,840,117.74 | 92.8 |
| 210102 | Нэмэгдэл | 175,686,800.00 | 203,844,754.02 | -28,157,954.02 | 116 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,288,000.00 | 57,970,163.72 | -33,682,163.72 | 238.6 |
| 210104 | Урамшуулал | 38,000,000.00 | 26,000,000.00 | 12,000,000.00 | 68.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 129,357,400.00 | 129,357,400.00 | 0.00 | 100 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 93,051,000.00 | 93,051,000.00 | 0.00 | 100 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,476,600.00 | 11,476,600.00 | 0.00 | 100 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,621,300.00 | 6,621,300.00 | 0.00 | 100 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,655,300.00 | 1,655,300.00 | 0.00 | 100 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,553,200.00 | 16,553,200.00 | 0.00 | 100 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,723,200.00 | 6,723,200.00 | 0.00 | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,363,200.00 | 1,363,200.00 | 0.00 | 100 |
| 210302 | Түлш, халаалт | 3,829,700.00 | 3,829,700.00 | 0.00 | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,418,000.00 | 1,418,000.00 | 0.00 | 100 |
| 210304 | Байрны түрээс | 112,300.00 | 112,300.00 | 0.00 | 100 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,596,000.00 | 17,420,802.00 | 2,175,198.00 | 88.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,600,000.00 | 11,586,605.00 | 2,013,395.00 | 85.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,390,000.00 | 2,385,000.00 | 5,000.00 | 99.7 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 1,581,540.00 | -81,540.00 | 105.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,106,000.00 | 1,867,657.00 | 238,343.00 | 88.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,466,000.00 | 3,397,000.00 | 69,000.00 | 98.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,144,000.00 | 1,144,000.00 | 0.00 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 2,262,000.00 | 2,253,000.00 | 9,000.00 | 99.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,500,000.00 | 5,500,000.00 | 0.00 | 100 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,089,100.00 | 1,089,100.00 | 0.00 | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,410,900.00 | 4,410,900.00 | 0.00 | 100 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1500000.00 | 1300000.00 | 200,000.00 | 86.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,500,000.00 | 1,300,000.00 | 200,000.00 | 86.6 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35447700.00 | 34947700.00 | 500,000.00 | 98.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 35,447,700.00 | 34,947,700.00 | 500,000.00 | 98.5 |

| | | | | | |
|-------------|---|-------------------------|-------------------------|-------------|------------|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 33,947,700.00 | 33,947,700.00 | 0.00 | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,500,000.00 | 1,000,000.00 | 500,000.00 | 66.6 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,139,248,800.00 | 1,139,248,800.00 | | 100 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,139,248,800.00 | 1,139,248,800.00 | | 100 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,139,248,800.00 | 1,139,248,800.00 | | 100 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 185,999.70 | | |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 48.00 | 48.00 | 0.00 | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 38.00 | 38.00 | 0.00 | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | 0.00 | 100 |
| 620004 | Гэрээт ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 | 100 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|---|----------------------|---------------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 12,261,500.00 | 9,024,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 12,261,500.00 | 9,024,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 12,261,500.00 | 7,024,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 310,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 310,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,261,500.00 | 6,714,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,261,500.00 | 6,714,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 2,000,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 2,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 2,000,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 12,261,500.00 | 9,024,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,261,500.00 | 9,024,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,310,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,261,500.00 | 6,714,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс /цаашид Улсын бүртгэлийн хэлтэс гэх/ нь “Бүртгэлийн ангиллыг тогтоох, үнэн зөв байдлыг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн сангийн улсын бүртгэл хөтлөлтийг хэрэгжүүлэх.” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлж, хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулах,
- Хэлтсийн албан хаагчдыг төрийн захиргааны удирдлагаар хангаж, бүртгэлийн үйлчилгээг олон нийтэд ил тод, чирэгдэлгүй хүргэх,
- Бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлж, чадавхжуулах.
- Иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, холбогдсон үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах,
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, холбогдсон үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангах,
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Улсын бүртгэлийн үйлчилгээнд мэдээллийн цахим санг ашиглах,
- Улсын бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулах,
- Суманд бүртгэгдсэн иргэний улсын бүртгэлийн мэдээллийг төв сүлжээнд шууд дамжуулж, мэдээллийн санг бүрдүүлэх,
- Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлт тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дугаар сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

УБХ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд УБЕГ-ын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас дотоод хяналт тавьдаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтэс нь ХЗДХ-ийн сайдын 2020 оны 5 дугаарын сарын 29-ний өдрийн А/87 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,408.4 мянган төгрөгөөр буюу 1.98 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|-------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 185.9 | | |
| Авлага | 19,800.0 | | |
| Урьдчилж гарсан зардал | - | - | - |
| Бараа материал | 83,717.2 | 100,899.7 | 17,182.5 |
| Үндсэн хөрөнгө | 219,520.3 | 215,915.3 | (3,605.0) |
| Нийт хөрөнгө | 323,223.4 | 316,815.0 | (6,408.4) |
| Өр төлбөр/урьдчилж орсон орлого | - | | |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 323,037.4 | 316,815.0 | (6,222.4) |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 323,223.4 | 316,815.0 | (6,408.4) |

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна. Үүнд:

- Авлага данс үлдэгдэлгүй байгаа нь өмнөх онд тайлагнагдсан авлагыг барагдуулснаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 100,899.7 мянган төгрөг болж 17,182.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 19,630.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 51,614.5 мянган төгрөгийн бараа материалыг УБЕГ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан болон 54,062.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 215,815.3 мянган төгрөг болж 3,605.0 мянган төгрөгөөр буурсан нь УБЕГ-аас 82,760.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 298,675.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 861,241.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 69,453.1 мянган төгрөгөөр бууруулж, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 57,162.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 15,250.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 11,388.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 3,546.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 6,034.0 төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 11,875.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,250.0 мянган төгрөгөөр бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ зардлыг 5,208.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 45,090.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн 791,788.20 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт дараах байдлаар тодотгол зохицуулалтыг хийсэн байна. Үүнд:

Цалин хөлс, нэмэгдэл урамшуул, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 371,503.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, урсгал шилжүүлгийн зардлыг 24,042.70 мянган төгрөгөөр бууруулж **1,139,248.8** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,139,248.8 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,139,248.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,136,304.6 мянган төгрөг буюу 99.7 хувьтай тайлагнагдсан байгаа нь хангамж, бараа материалын зардлыг 2,175.2 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 69.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 200.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 500.0 мянган төгрөгөөр гэх мэт батлагдсан төсвийг нийт **2,944.2** мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--------------------|--|--------------------|--------------------|----------------|-------------|
| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,103,801.1 | 1,101,356.9 | 2,444.2 | 99.7 |
| 2 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 35,447.7 | 34,947.7 | 500.0 | 98.6 |
| | Нийт | 1,139,248.7 | 1,136,304.6 | 2,944.2 | 99.7 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд УБЕГ-аас аймаг, сумын ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулах зардалд 9,024.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- Аймаг, сумын ИТХ-ын нөхөн сонгуулийн хэсгийн хороодын итгэмжлэгдсэн ажилтнуудын урамшуулал, НДШ-ийн зардалд 6,714.0 мянган төгрөг,
- Шатахууны зардалд 310.0 мянган төгрөг,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 2,000.0

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Ундраа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 750,204.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,502.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус газрын батлагдсан төсөв материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,254,040.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 12,540.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд тус газар нь хангамж бараа материалын зардлыг 2,175.2 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 500.0 мянган төгрөгөөр, урсгал эд хогшлын зардлыг 69.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 200.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй 992.7 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргаагүй, Сэлэнгэ ариутгал ХХК-аар 2021 онд гүйцэтгүүлсэн ариутгалын ажлын хөлс 175.2 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлагын биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 1 | 1,167.9 | 1 | 1,167.9 | 100 |
| Нийт дүн | 1 | 1,167.9 | 1 | 1,167.9 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт 7,700.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, албан шаардлага өгөв.

5.1 Албан шаардлага

1. Цалингийн урьдчилгааны 24,368.2 мянган төгрөгийг давхардуулан тайлагнаж, НДШ, ХХОАТ-ыг тооцоолсноос шалтгаалан НДШ-д 5,848.4 мянган төгрөгийг, ХХОАТ-д 1,852.0 мянган төгрөгийг зэрэг нийт **7,700.4** мянган төгрөгийг илүү шилжүүлсэн боловч авлага үүсгэлгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ, 20.2.5: "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулсны үндсэн дээр ажил, гүйлгээг гүйцэтгэх, төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй ажиллах, үүссэн авлагыг тооцоо нийлж, барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|--|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | | |
| | | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|----------------|---------|-----|--------------------------------------|-----|---|---------------------|-----|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| НДШ, ХХОАТ-ыг илүү шилжүүлж, авлага үүсгэсэн | | | | | 1 | 7,700.4 | | | | | | | | |
| Дүн | | | | | 1 | 7,700.4 | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | - | - | | | | | | |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | - | - | | | | | | |
| Нийт дүн | - | - | | | | | | |